БиДиСЕК ХК
ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИ

# ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2022



**TOP 20**

- TOP 20 INDEX ON MSE

**I**

- MONGOLIAN STOCK EXCHANGE TIER – I LISTED COMPANY
- FIRST PUBLIC BROKERAGE COMPANY

- GLOBAL BANKING FINANCE, 2021
- BEST INVESTMENT BANK MONGOLIA
- BEST BROKERAGE COMPANY MONGOLIA

- GRAND BULL AWARDS, 2018
- BEST UNDERWRITER
- BEST BROKER DEALER COMPANY

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

**“ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК**-ийн **2 ИХ НАЯД ТӨГРӨГ ХҮРТЭЛХ** нээлттэй бондыг олон нийтэд санал болгон, 2021 оны 4 сараас хойш нийт **1.1 ИХ НАЯД** төгрөгийг татан төвлөрүүлэв.
2022 оны 5 сард ЭТТ хөвөгч хүүтэй бондыг олон нийтэд санал болгон **76.6 ТЭРБУМ** төгрөгийг татан төвлөрүүлэв.

2022 оны 4 сарын 21-ний өдөр **“ХААН БАНК” ХХК**-ийн **IPO** үнэт цаасны танилцуулга Монгол Банк, СЗХ, МХБ-д хүргүүлэв**.**

**“Хүрэн Толгой Коал Майнинг” ХХК**-ийн төгрөгийн болон ам.доллар-төгрөгийн ханштай уясан хаалттай бондын эхний транчаар **18.7 ТЭРБУМ** төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн.

**“БИД” ББСБ**-ийн ББЗЗ-д төгрөгийн бондын санхүүжилт татах ажиллагаанд БиДиСЕК ҮЦК ХК нь андеррайтераар ажиллан ББЗЗ-д мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгох **ЗӨВШӨӨРЛИЙГ** авав.

2021 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд **50 ТӨГРӨГИЙГ** хувьцаа эзэмшигчдэдээ **НОГДОЛ АШИГ** болгон тараав. МХБ-ийн **I** ангиллын компаниуд дунд ногдол ашгийн өгөөжөөр “АПУ” ХК, “Ард Даатгал” ХК-ын араас **3-Т ЖАГСАВ.**

Харилцагчдын тоо **+310,000**-д хүрэв.

2022 оны эхний хагас жилд **НИЙТ 98.7 ТЭРБУМ** ТӨГРӨГИЙН арилжаа хийж гүйцэтгэн, зах зээл дэх **МАНЛАЙЛАГЧИЙН** байр сууриа хадгалав.

Гадаад арилжааны зуучлал: Харилцагчдын тоо **19 ХУВИАР** өсч, **$ 3.6 САЯ** арилжаа хийгдлээ.

Андеррайтер төвтэй **IPO СИСТЕМ** хөгжүүлэлт

Зах зээлийн нөхцөл байдалд уялдуулан компанийн зорилго, зорилт, логот шинэчлэх /**КОМПАНИЙН РЕ-БРЕНДИНГ**/ ажлыг 2022 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн.

## АЛСЫН ХАРАА

"Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, технологид суурилсан санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжиж чинээлэг харилцагч, нийгмийн баялаг үнэт зүйлийг бий болгох."

## ЗОРИЛГО

### Богино хугацаанд

Гадаад харилцааг өргөжүүлэх, үнэт цаасны арилжааг идэвхжүүлэх, компанийн боловсон хүчнийг чадваржуулах, харилцагчдыг хөрөнгийн зах зээлийн мэдээгээр найдвартай хангах;

### Дунд хугацаанд

Үндэсний томоохон үйлдвэрлэгчдийг дэмжих, олон улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаагаа явуулах, хөрөнгийн зах зээлд оролцогчдын хүрээг нэмэгдүүлэх;

### Урт хугацаанд

Олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулах, үндэсний томоохон хувьцаат компаниудыг шинээр бий болгох;

## ҮНЭТ ЗҮЙЛС

**PIONEERS IN CAPITAL MARKET**
/Зах зээлийн анхдагч/

**LOYALTY TO OUR CLIENTS**
/Харилцагч төвтэй/

**PROFESSIONALISM**
/Мэргэжлийн хандлага/

**TRANSPARENCY**
/Ил тод нээлттэй байдал/

**PRUDENCE**
/Боломжийг бүрэн ашиглах чадвар/

# КОМПАНИЙН УДИРДЛАГА



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**Б.Лхагвадорж**
БиДиСЕК ҮЦК ХК,
Тэргүүн дэд захирал,
ТУЗ-ийн дарга



**Д.Даянбилгүүн**
БиДиСЕК ҮЦК ХК,
Гүйцэтгэх захирал



**Н.Батгэрэл**
БиДиСЕК ҮЦК ХК,
Дэд захирал



**О.Уранбайгал**
БиДиСЕК ҮЦК ХК,
Back Office VP

ТУЗ-д одоогийн менежментийн багийн удирдлагууд ажиллаж байна.



**Д.Амгаланбаяр**
MSM ХХК,
Захиргааны мэргэжилтэн



**О.Лхагвасүрэн**
Сэцэн Билгүүн ХХК,
Гүйцэтгэх захирал



**Б.Энхбаяр**
Sanaa EXE ХХК,
Гүйцэтгэх захирал

ТУЗ-д санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн туршлагатай төлөөллүүд ажиллаж байна.



**Улуч Бингол**
Импера Капитал
Дэд ерөнхийлөгч



**Хитоши Тани**
EXE корпораци
Ерөнхийлөгч

ТУЗ-ийн гишүүнээр Турк, Япон улсын нэр бүхий томоохон компаниудын удирдлага, хөрөнгө оруулагчдын төлөөлөгчид сонгогдон ажиллаж байна.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ТҮР ХОРООД

**Нэр дэвшүүлэх дэд хороо:**

| | |
|---|---|
| Дарга: | Д.Даянбилгүүн |
| Гишүүд: | Улуч Бингол |
| | Б.Энхбаяр |

**Аудитын хороо:**

| | |
|---|---|
| Дарга: | Д.Амгаланбаяр |
| Гишүүд: | О.Лхагвасүрэн |
| | О.Уранбайгал |

**Цалин урамшууллын хороо:**

| | |
|---|---|
| Дарга: | Н.Батгэрэл |
| Гишүүд: | Хитоши Тани |
| | Д.Амгаланбаяр |

# КОМПАНИЙН УДИРДЛАГА

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ




## УДИРДЛАГЫН БАГ

| Нэр | Компанид ажилласан жил | Албан тушаал |
|---|---|---|
| Д.Даянбилгүүн | 25 | Гүйцэтгэх захирал |
| Б.Лхагвадорж | 25 | Тэргүүн дэд захирал |
| Н.Батгэрэл | 16 | Дэд захирал |
| С. Зориг | 1.6 | Ахлах зөвлөх |
| С.Пүрэвсүрэн | 18 | Дотоод албаны менежер |
| Ш.Шинэбаяр | 15 | Хөрөнгө оруулалтын албаны захирал |
| С. Дамдинсүрэн | 14 | IT албаны захирал |
| О. Уранбайгал | 13 | Back Office албаны захирал |
| Б.Онон | 4 | Харилцагчийн албаны захирал |

# ХУВЬЦААНЫ ХАНШИЙН МЭДЭЭЛЭЛ

## BDS АРИЛЖААНЫ ГРАФИК (2021.12.31-2022.06.30)




| | |
|---|---|
| Хаалтын ханш /2022.08.05/ | 1,175 ₮ |
| Зах зээлийн үнэлгээ | 16,091,487,525₮ |
| Нийт эргэлтэнд гаргасан хувьцааны тоо | 13,694,883 |
| 52 хоног | 900₮-1366₮ |

# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2022Н1

| /сая төгрөг/ | 2021.12.31 | 2022.6.30 |
|---|---|---|
| **1. ХӨРӨНГӨ** | | |
| ***1.1 Эргэлтийн хөрөнгө*** | | |
| 1.1.1 Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 1,774.1 | 1,009.6 |
| 1.1.2 Авлага | 4,312.4 | 5,444.4 |
| 1.1.3 Санхүүгийн хөрөнгө | 14,776.6 | 12,336.3 |
| 1.1.4 Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 17.5 | 59.6 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **20,880.6** | **18,849.9** |
| ***1.2 Эргэлтийн бус хөрөнгө*** | | |
| 1.2.1 Үндсэн хөрөнгө | 4,414.3 | 4,420.6 |
| 1.2.2 Биет бус хөрөнгө | 12.5 | 16.2 |
| 1.2.3 Урт хугацаат хөрөнгө оруулалт | 51.0 | 51.0 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **4,477.8** | **4,487.8** |
| **Нийт хөрөнгийн дүн** | **25,358.4** | **23,337.7** |
| **2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| ***2.1 Өр төлбөр*** | | |
| 2.1.1 Богино хугацаат өр төлбөр | 7,270.8 | 1,530.3 |
| 2.1.2 Урт хугацаат өр төлбөр | - | 7,335.9 |
| **Өр төлбөрийн дүн** | **7,270.8** | **8,866.2** |
| ***2.2 Эздийн өмч*** | | |
| 2.2.1 Хувьцаат капитал | 1,369.5 | 1,369.5 |
| 2.2.2 Нэмж төлөгдсөн капитал | 7,957.3 | 7,957.3 |
| 2.2.3 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 3,824.5 | 3,824.5 |
| 2.2.4 Хуримтлагдсан ашиг | 4,936.3 | 1,320.1 |
| **Эздийн өмчийн дүн** | **18,087.6** | **14,471.5** |
| **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | **25,358.4** | **23,337.7** |

## ТОП 10 ҮЦК НИЙТ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ /ҮЕ2021/



# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2022Н1

## НИЙТ ХӨРӨНГӨ




## НИЙТ ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ




## НИЙТ ӨР ТӨЛБӨР




2022 оны хагас жилд компанийн нийт өр төлбөр нэмэгдсэн нь урт хугацаат зээл нэмэгдсэнтэй холбоотой. 6-р сарын 30-нд компани хөрөнгийн зах зээл дээр гарч байгаа шинэ бүтээгдэхүүнийг дэмжих зорилгоор бага хүүтэй ам.долларын эргэлтийн хөрөнгийн зээл авсан бөгөөд 6-р сарын 30-ны байдлаар хөрөнгө оруулалт хийгээгүй буюу бэлэн мөнгө хэлбэрээр компанийн дансанд байршиж байсан.

# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД-2022Н1

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО




## ЦЭВЭР АШИГ




2022 оны хагас жилийн гүйцэтгэлээр компанийн үйл ажиллагааны орлого өмнөх оны үзүүлэлтээс 47%-р багассан нь андеррайтерийн үйл ажиллагааны орлого буурсантай холбоотой.
Бид "Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл-н" дагуу Хаан Банкны IPO-г 6 сард хийхээр төлөвлөж байсан бөгөөд уг хугацаанд компани бусад IPO болон FPO төслүүдээ хойшлуулсан нь андеррайтерийн үйл ажиллагааны орлого буурахад нөлөөлсөн.

Компани алдагдалтай гаргасан нь дараах хоёр шалтгаантай байсан:

- 2022 оны эхний хагас жилд Дэлхийн томоохон индексүүд /дунджаар -20.0% / болон Монголын ТОП 20 Индекс /-25.4/ уналт үзүүлээд байна. Үүнийг дагаад манай компанийн хөрөнгө оруулалтын багцын зах зээлийн үнэлгээ эхний хагас жилд буурсан. (Ард даатгал ХК, Бодь даатгал ХК, Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК гм).
- Ам.долларын зээлтэй байснаас үүдэн ханшийн зөрүүний алдагдал хүлээсэн.

# АНДЕРРАЙТЕРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## Эрдэнэс-Тавантолгой ХК

Нээлттэй бонд

2021 оны 4 сараас эхлэн МХБ дээр ЭТТ нээлттэй бондын захиалга хэд хэдэн үе шатаар олон нийтэд санал болгож байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1.1 их наяд төгрөг татан төвлөрүүлээд байна.

2022 оны 5 сард хөвөгч хүүтэй /бодлогын хүү+4%/ бонд гарган, 76.6 ТЭРБУМ төгрөг татан төвлөрүүлсэн.

**Lead Underwriter**
2021 оны 4 сараас

## ХААН Банк ХХК

IPO гаргах ерөнхий төлөвлөгөө

ХААН Банк ХХК-ийн андеррайтераар шалгаран 2021 оны 05 сард гэрээ байгуулсан.

Хуулийн хугацаанд буюу 2022 оны 4 сарын 21-нд Хаан Банк-ны үнэт цаасны танилцуулга, бусад холбогдох материалыг Монгол Банк, СЗХ, МХБ-д хүргүүлсэн.

**Lead Underwriter**
2021 оны 5 сараас

## Хүрэн Толгой Коал Майнинг ХХК

Хаалттай бонд

Монголын томоохон нүүрс экспортын компани болох "Хүрэн Толгой Коал Майнинг" ХХК-ийн биржийн бус зах зээлд төгрөгийн болон ам.доллар-төгрөгийн ханштай уясан хаалттай бондын эхний транчаар 18.7 тэр.төг амжилттай татан төвлөрүүлсэн.

**Underwriter**
2022 он

## "БИД" ББСБ

Хаалттай бонд

ББСБ-ын салбарын томоохон байгууллагуудын нэг "БИД" ББСБ-ийн биржийн бус зах зээлд төгрөгийн бондын санхүүжилт татах ажиллагаанд БиДиСЕК ҮЦК ХК нь андеррайтераар ажиллан ББЗЗ-д мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгох зөвшөөрлийг аваад байна.

**Underwriter**
2022 он

# БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## ТОП 10 ҮЦК-ЫН МХБ-ИЙН НИЙТ АРИЛЖААНД ЭЗЛЭХ ХУВЬ




## ШИНЭЭР НЭЭГДСЭН ДАНС

+10,000




**НИЙТ ХАРИЛЦАГЧДЫН ТОО**

+310,000

## БОНДЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА




Нийт 4 бонд болон ХБҮЦ МХБ-ийн анхдагч зах зээл дээр арилжигдан, 134.7 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн. Үүнээс манай компани 56.7% хувь буюу 76.3 тэрбум төгрөгийн арилжаа дангаараа гүйцэтгэсэн.

# ОНЛАЙН БРОКЕР ҮЙЛЧИЛГЭЭ

## BDSEC ОНЛАЙН БРОКЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАВУУ ТАЛ:

- Жилийн хураамж – 0₮
- Харилцагч салбарт ирэх шаардлагагүй.
- Вэб хөтөчөөр дамжуулан арилжаанд оролцох боломжтой.
- Мобайл апп ИЛҮҮ ХУРДАН, ХЯЛБАР
- www.dbx.bdsec.mn
- Арилжааны төлбөр тооцоо, ногдол ашиг, хүү Онлайнаар гүйлгээ хийх буюу гарган авах боломж

GET IT ON Google Play

Download on the App Store

## ОНЛАЙНААР ДАРААХ ҮЙЛЧИЛГЭЭГ АВАХ БОЛОМЖТОЙ:

- Хувьцаа, бонд худалдах, худалдан авах захиалга өгөх
- Дансны үлдэгдэл хянах
- Үнэт цаасны ханш харах
- IPO захиалга өгөх
- Дансны дэлгэрэнгүй хуулга
- Мөнгө хүсэх илгээх

# ГАДААД АРИЛЖААНД ЗУУЧЛАХ

## SAXO BANK

- Saxo Bank нь 1992 онд байгуулагдсан дэлхийд тэргүүлэгч арилжааны, хөрөнгө оруулалтын компани.
- Дани Улсын Копенхаген хотод төвтэй бөгөөд дэлхийн санхүүгийн төвүүд дэх өөрийн салбараар дамжуулан харилцагчиддаа үйлчилгээгээ хүргэж байна.

## SAXO БАНКААР ДАМЖУУЛАН ГАДААД ОРОЛЦОХ ДАВУУ ТАЛ

Хамгийн цогц, ашиглахад хялбар, бүгдийг нэг дороос удирдаж болдог арилжааны платформ

Дансаа цэнэглэх анхны хөрөнгө оруулалтын хэмжээ бага буюу 100 ам.доллар

Иж бүрэн, чанарын өндөр түвшин бүхий судалгааг төлбөртэй болон төлбөргүй хэлбэрээр авч болно

**Арилжаа**

Арилжаа: +11%

**Харилцагчид**

Хувь хүн: +19%

## ДАНС НЭЭЛГЭХЭД БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ

Дараах хүчин төгөлдөр бичиг баримтыг бүрдүүлээд, данс нээх хүсэлтээ илгээхэд данс нээх хүсэлтээ илгээнэ.

**Хувь хүн**

- Гадаад паспорт
- Иргэний үнэмлэх
- Харилцагчийн маягт

**Байгууллага**

- Компанийн бичиг баримт
- 25%-иас дээш хувьцаа эзэмшигчдийн бичиг баримт
- Харилцагчийн маягт

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

www.agm.bdsec.mn

Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний хүрээнд Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах вэб аппликэйшнийг хөгжүүлсэн бөгөөд 8 хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг биет болон онлайн хэлбэрээр амжилттай зохион байгууллаа.

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН КОМПАНИУД:

- АПУ ХК
- ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЭЙШН ХК
- БОГД БАНК ХК
- БОДЬ ДААТГАЛ ХК
- **Э-Транс Ложистикс ХК**
- БАЯН ТЭЭГ ХК
- ГОВИЙН ӨНДӨР ХК
- ХОТ ДЕВЕЛОПМЕНТ ХК

# IT СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭЛТ










Харилцагчид манай үйлчилгээг онлайнаар хялбар авах боломж нөхцлийн бүрдүүлж илүү сайжруулах зорилготойгоор **ВЕБ** болон **АПП-г** байнга хөгжүүлж байна.

## АНДЕРРАЙТЕР ТӨВТЭЙ IPO СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭЛТ




Андеррайтерын компани анхдагчийн арилжааг зохион байгуулах хууль эрх зүйн орчин боломж бүрдсэн. Тиймээс “Анд Системс” ХХК-тай хамтран энэхүү системийг зах зээлд нэвтрүүлэхээр системийн судалгаа, хөгжүүлэлтийн шатны ажлууд хийж гүйцэтгэсэн бөгөөд уг систем туршилтын шатандаа үргэлжилж байна.

Тус системд бүх ҮЦК **веб интерфейс** болон **API**-р холбогдож захиалга оруулах боломжтой. Мөн бусад Андррайтерийн компани ашиглан IPO ийн захиалгаа авах, гуравдагч системтэй холбох боломж нээлттэй.

# 2022Н2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

## ХАРИЛЦАГЧДЫН ТОО

+320,000

Онлайн харилцагчийн тоог
+**3 ДАХИН** нэмэгдүүлэх

## SAXO ХАРИЛЦАГЧДЫН ТОО

+300

+5

## ТӨСЛИЙН СУДАЛГАА

**+30 төслийн судалгаа**

**+5 төсөл дээр ажиллах**

## MSE-АРИЛЖААНЫ ДҮН

/Тэрбум төгрөг/

**+400.0**

## SAXO -АРИЛЖААНЫ ДҮН

/Сая доллар/

**+6.0**

## IPO & БОНД

ХААН БАНК — **₮183.3 тэрбум**

БИД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ — **₮3 тэрбум**

KHUREN TOLGOI COAL MINING — **₮31.6 тэрбум (үүнээс ₮18.7 тэрбум татан төвлөрүүлсэн)**

**+2 IPO**

**хийхээр төлөвлөн, ажиллаж байна.**

БиДиСЕК ХК
ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИ

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.

**БИДИСЕК ҮЦК ХК**
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бээжингийн гудамж 27/1, БиДиСЕК ҮЦК ХК-ийн байр
Утас: 976-11-313108, 321763, 7555-1919
И-мэйл: info@bdsec.mn

: www.bdsec.mn

: www.facebook.com/BDSecJSC

: www.twitter.com/BDSecJSC